



“ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН
УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ
ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОРОО



ОЮУ ТОЛГОЙН ОРОН
НУТГИЙН АЖИЛЧДЫН
ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОРОО



ХАМТЫН ГЭРЭЭ

2025-2027



ХАМТЫН ГЭРЭЭ

2025-2027

“Оюу толгой” ХХК болон "Оюу толгой" ХХК-ийн Уул уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороо, Оюу толгойн Орон Нутгийн Ажилчдын Үйлдвэрчний эвлэлийн хороодын хамтын хэлэлцээ амжилттай өндөрлөж, 11 сарын 21-ний өдөр ажилтнуудын хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах тогтвортой, гурван жилийн урт хугацааны Хамтын гэрээг үзэглэлээ.

Энэхүү гэрээ нь ажилтнууд болон тэдний гэр бүлд чиглэсэн үр өгөөжтэй хуулийн нөхцөлийг сайжруулсан гэрээ болсныг танилцуулахдаа таатай байна. Хамтын гэрээ нь дараах хуудсанд дурдагдсан өргөн агуулга бүхий 10 бүлгээс бүрдэнэ. Иймд гэрээний төсөлд тусгагдсан асуудал бүрийг шийдвэрлэхийн тулд талуудын зүгээс ихээхэн хичээл зүтгэл, цаг хугацаа зарцуулсан төдийгүй ажилтны цалин хөлсөнд шууд нөлөөлөх сайжруулалт, нэмэлт хөтөлбөрүүд тусгагдсан.

ХАМТЫН ГЭРЭЭНИЙ ХАМРАХ БҮЛЭГ

- ✓ I Бүлэг Гэрээний зорилго
- ✓ II Бүлэг Нийтлэг үндэслэл
- ✓ III Бүлэг Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны баталгааны талаар
- ✓ IV Бүлэг Цалин хөлс
- ✓ V Бүлэг Ажилтны нийгмийн хамгаалал, ажилтнуудад үзүүлэх хөнгөлөлтийн талаар
- ✓ VI Бүлэг Ажил, амралтын хуваарийн талаар
- ✓ VII Бүлэг Мэргэжил олгох, дээшлүүлэх талаар
- ✓ VIII Бүлэг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар
- ✓ IX Бүлэг Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа
- ✓ X Бүлэг Хамтын гэрээний хэрэгжилт, хяналт тавих, биелэлтийг дүгнэх

**ТА БҮХЭНДЭЭ ХАМТЫН ГЭРЭЭГЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТОМООХОН ӨӨРЧЛӨЛТ
САЙЖРУУЛАЛТУУДЫГ ТАНИЛЦУУЛЪЯ.**



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

ҮНДСЭН ЦАЛИНД ОРОХ ӨӨРЧЛӨЛТ

$$\begin{array}{l} \text{САРЫН ҮНДСЭН} \\ \textbf{ЦАЛИН} \\ \text{(ОДОО БАЙГАА)} \end{array} + \textbf{200} \text{ АМ.ДОЛЛАР} = \begin{array}{l} \textbf{ҮНДСЭН ЦАЛИН} \\ \text{(ХАМТЫН ГЭРЭЭНИЙ ДАГУУ} \\ \text{НЭМЭГДҮҮЛСЭН БАЙДЛААР)} \end{array}$$

Хамтын гэрээ үйлчлэх эхний жил болох 2025 онд “Оюу толгой” компанийн нийт ажилтнуудын үндсэн цалинг 200 ам.доллараар нэмэгдүүлэх хамтын тохиролцоонд хүрэв.

Үндсэн цалин хөлсний нэмэгдэл нь цалин нэмэгдэх тогтсон процессын дагуу 2025 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж 3 дугаар сарын 25-ны өдрийн цалинд тооцогдож орох болно.



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

ҮНДСЭН ЦАЛИНД ОРОХ ӨӨРЧЛӨЛТ



2026, 2027 онд үндсэн цалинг тус бүр 3 хувиар нэмэгдүүлэхээр
Хамтын гэрээнд тохиролцсон.


Үндсэн цалинг ийнхүү нэмэгдүүлснээр цаашид үндсэн цалингаас хувь тооцон олгогдох бүхий л нэмэгдэл хөлс, олговоруудыг давхар нэмэгдүүлэх төдийгүй ажилтны гарт очих цалин хөлсний нийт хэмжээг мөн нэмэгдүүлж байгаа юм.



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

ИЛҮҮ ЦАГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС

“Илүү цаг”-ийн хөлсийг нэмэгдүүлэн олгохоор боллоо. Ийнхүү олгохдоо өдөр бүр 8 (хэвийн бус нөхцөлтэй ажилчдад 7) цагаас дээш ажиллах илүү цагийг дундаж цалин хөлсийг 1.6 дахин нэмэгдүүлж олгоно.



8 ЦАГ

ЕРДИЙН АЖИЛЛАХ

ИЛҮҮ ЦАГ
ДУНДАЖ ЦАЛИНГ
1.6 ДАХИН
НЭМЭГДҮҮЛЭХ

Илүү цагийн нэмэгдэл хөлсийг 2024 оны 12 сарын 25-наас эхлэн цаг бүртгэлийн системд хэрэгжүүлж эхлэх бөгөөд 2025 оны 2 сарын 10-ны өдрийн цалингаас олгогдож эхэлнэ.



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

ИЛҮҮ ЦАГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС: ЖИШЭЭЛБЭЛ

ХЭВИЙН БУС НӨХЦӨЛГҮЙ АЖИЛТНЫ ХУВЬД
/Тухайн сар 30 хоногтой гэж үзвэл/

САРД АМРАХ
ХОНОГ 14

САРД АЖИЛЛАСАН
ХОНОГ 16

ӨДРИЙН АЖЛЫН
ЦАГ 12

НИЙТ АЖИЛЛАСАН ЦАГ $12 \times 16 = 192$

ЕРДИЙН АЖИЛЛАХ ЦАГ
 $8 \times 16 = 128$

ИЛҮҮ ЦАГ
 $4 \times 16 = 64$

ИЛҮҮ ЦАГИЙН ТООЦООЛОЛ
=
64 ЦАГ X ДУНДАЖ ЦАЛИН X 1.6

ХЭВИЙН БУС НӨХЦӨЛТЭЙ АЖИЛТНЫ ХУВЬД
/Тухайн сар 30 хоногтой гэж үзвэл/

САРД АМРАХ
ХОНОГ 14

САРД АЖИЛЛАСАН
ХОНОГ 16

ӨДРИЙН АЖЛЫН
ЦАГ 12

НИЙТ АЖИЛЛАСАН ЦАГ $12 \times 16 = 192$

ЕРДИЙН АЖИЛЛАХ ЦАГ
 $7 \times 16 = 112$

ИЛҮҮ ЦАГ
 $5 \times 16 = 80$

ИЛҮҮ ЦАГИЙН ТООЦООЛОЛ
=
80 ЦАГ X ДУНДАЖ ЦАЛИН X 1.6

Хэлтэс багуудын өдөрт ажиллах ажлын цаг одоогийн хэвээр үргэлжлэхийг анхаарна уу.



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

ШӨНИЙН ЦАГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС

ТОМЬЁОЛОЛ:

$$\left(\text{ДУНДАЖ ЦАЛИН} \times 1.3 - \text{ЦАГИЙН ҮНДСЭН ЦАЛИН}^* \right) \times \text{ШӨНИЙН ЭЭЛЖИЙН ЦАГ}$$

Шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг Дундаж цалин хөлсийг 1.2 дахин нэмэгдүүлэн олгож буйг сайжруулан **1.3 дахин нэмэгдүүлж** олгоно. Ингэхдээ одоогийн томьёоллыг хадгалах болно.

*Сарын үндсэн цалинд багтсан давхардаж олгогдож байгаа цагийн цалин болно.



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН ХУВААГЧ

Дундаж цалин хөлсний одоогийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар хэвээр хадгална.

- ☒ Үндсэн цалин
- ☒ Уртын ээлжийн нэмэгдэл
- ☒ Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл
- ☒ Засвар үйлчилгээний зогсолтгүй үйл ажиллагааны нэмэгдэл хөлс
- ☒ Зогсолтгүй үйл ажиллагааны нэмэгдэл хөлс
- ☒ Ээлжийн амралтын цалин



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН ХУВААГЧ

Дундаж цалин хөлсний үнэлгээг тооцоолоход ашиглагдах
ажилласан цагийн хуваагчийн дээд хязгаар **168 цаг** хүртэл байна.


168

168 цагаас дээш ажилласан сарууд болон ажлын зайлшгүй шаардлагаар сунаж ажилласан тохиолдлуудад ажилтны Дундаж цагийн үнэлгээ ажилласан нийт цагаас шалтгаалж буурахгүй байх таатай нөхцөлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээ юм.



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

ЦАЛИН ХӨЛСНИЙ БОДОЛТЫГ САЙЖРУУЛАХ, ЭНГИЙН ОЙЛГОМЖТОЙ БОЛГОХ



Талууд цаг бүртгэл, цалин бодолтын системийн сайжруулалтын төслийг хамтран хэрэгжүүлнэ. Энэхүү төслийн хүрээнд мөн урт хугацааны чөлөөтэй үеийн цалин хөлсний бодолтыг нягтлан, сайжруулах дээр хамтран ажиллана.



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

ХООЛ, УНААНЫ ХӨНГӨЛӨЛТ

ШИНЭЧЛЭГДСЭН ХӨНГӨЛӨЛТ

1,000,000₮



ӨМНӨХ ХӨНГӨЛӨЛТ
800,000₮

(500,000₮ БАЙСНЫГ
2024.04 САРД НЭМЭГДҮҮЛСЭН.)

Улаанбаатар, Даланзадгад, Ханбогд оффисын
ажилтнуудын Хоол, унааны хөнгөлөлтийг

1 сая төгрөг
болгон нэмэгдүүлэв.

- ✓ Тус хөнгөлөлтийг оффисын ажилтны ажиллах байршлаас үл хамааран бүтэн олгох юм.
- ✓ Уурхайн цогцолбор болон Улаанбаатар оффист хэсэгчилсэн хуваариар ажилладаг ажилтнуудын хувьд дээрх зарчим мөн адил хамаарна.

*2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс хэрэгжиж,
2025 оны 2 дугаар сарын 10-ны цалинд олгоно.



ЦАЛИН ХӨЛС, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ САЙЖРУУЛАЛТУУД

АЖИЛТНУУДЫН ГАРТ ОЛГОЖ БУЙ ЦАЛИН ХӨЛСӨНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ ЯМАР БАЙХ ВЭ?



Эдгээр сайжруулалт нь нийт ажилтнуудын хувьд эерэг нөлөөтэй байгаа ба ажилтан тус бүрийн ажлын байршил, хуваарь, нөхцөлөөс хамаарч ялгаатай байх болно.



Уурхайн ажилтнуудын хувьд:

- **ИЛҮҮ ЦАГ**
- **ШӨНИЙН ЭЭЛЖИЙН НЭМЭГДЭЛ**
- **БУСАД ОЛОН ТӨРЛИЙН НЭМЭГДЛҮҮДЭЭС** шалтгаалж гарт олгох цалин илүү өндөр хувиар нэмэгдэх юм.



БУСАД ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН ХӨТӨЛБӨР, ТЭТГЭМЖ

СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ



“Оюу толгой” ХХК-ийн үндсэн ажилтны хүүхдүүдэд зориулан Дотоодын их дээд сургуульд суралцах тэтгэлгийг жил бүр 30 оюутанд олгоно. Эдгээр оюутнууд нь “Залуусын Хөгжлийн Хөтөлбөр”-т хамрагдах боломжтой байх юм.

**Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийг компанийн зүгээс ажилтнуудынхаа гэр бүлд зориулан хэрэгжүүлэхээр санаачилсан болно.*



БУСАД ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН ХӨТӨЛБӨР, ТЭТГЭМЖ

АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ

- ✓ Амаржсаны тэтгэмжийг сайжруулан Нийгмийн даатгалын сангаас олгодог жирэмсний болон амарсны 4 сарын тэтгэмжээс гадна эцэгт олгох чөлөөний тэтгэмжтэй адилаар 18 (арван найм) долоо хоногийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэмж олгоно.

ОДООГИЙНХ

*Эхэд олгох чөлөөний хугацаа **6 сар**.

4 САРЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТЭТГЭМЖ
БОЛОН ҮНДСЭН ЦАЛИНГИЙН ЗӨРҮҮ

+

2 САРЫН ҮНДСЭН ЦАЛИН

ШИНЭЧЛЭГДСЭН

*Эхэд олгох чөлөөний хугацаа **6 сар** хэвээр үргэлжилнэ.

4 САРЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТЭТГЭМЖ

+

4 САРЫН ҮНДСЭН ЦАЛИН

*Хамтын гэрээ хуулийн дагуу баталгаажсаны дараа хэрэгжиж эхэлнэ.



БУСАД ХӨНГӨЛӨЛТ,
УРАМШУУЛЛЫН
ХӨТӨЛБӨР, ТЭТГЭМЖ

ГЭНЭТИЙН АЮУЛ ОСЛЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ



Ажилтнуудын оршин суудаг орон гэр гамшиг, аюулт үзэгдэл, осолд нэрвэгдэж орон гэр нь сүйдсэн тохиолдолд **10 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг нэг удаа** үзүүлнэ. Компанид нэг гэр бүлээс хоёр ажилтан (эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү) ажилладаг тохиолдолд энэхүү буцалтгүй тусламжийг зөвхөн нэг удаа олгоно.

*Хамтын гэрээ хуулийн дагуу баталгаажсаны дараа хэрэгжиж эхэлнэ.




БУСАД ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН ХӨТӨЛБӨР, ТЭТГЭМЖ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХАРИЛЦАА ДУУССАНЫ ТЭТГЭМЖ


- ✓ Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгасны тэтгэмжийг сайжруулан 10 болон 15 жилээс дээш компанид ажилласан ажилтнуудад олгогдох тэтгэмжийн хэмжээг дараах байдлаар сайжруулав.

11-14
ЖИЛ АЖИЛЛАСАН



9 САРЫН
ҮНДСЭН ЦАЛИН

15-ААС ДЭЭШ
ЖИЛ АЖИЛЛАСАН



12 САРЫН
ҮНДСЭН ЦАЛИН

*Аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан;
орон тоо хасагдсан; ажилтны тоог цөөрүүлсэн тохиолдолд.

*Хамтын гэрээ хуулийн дагуу баталгаажсаны дараа хэрэгжиж эхэлнэ.



БУСАД ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН ХӨТӨЛБӨР, ТЭТГЭМЖ

БУСАД ОНЦЛОХ САЙЖРУУЛАЛТУУД, ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

- ☑ Хавсран болон Орлон гүйцэтгэсний нэмэгдлийн нөхцөлүүдийг илүү тодорхой болгож **20 болон 25** хувь болгон сайжруулав.
*2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс хэрэгжиж эхэлнэ.
- ☑ Оператор болон техник мэргэжлийн ажлын байрны ур чадварын ялгааг нягтлах ажлыг хамтарсан ажлын хэсэг байгуулан хийнэ.
- ☑ Компани болон Үйлдвэрчний Эвлэлийн Хороодын хамтран ажиллах зарчим, тогтолцоог тодорхой болгон зохицуулсан.



БУСАД ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН ХӨТӨЛБӨР, ТЭТГЭМЖ

БУСАД ОНЦЛОХ САЙЖРУУЛАЛТУУД, ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

☑ Одоогийн хэрэгжиж буй хамтын гэрээний хүрээнд ажилтнууд болон тэдний гэр бүлд чиглэсэн үр өгөөжтэй дараах төсөл, хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх юм. Үүнд:

- Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд гэр бүлийн 2 гишүүнийг нэмэлтээр хамруулах;
- Тэтгэвэр хуримтлалын сан;
- Амь насны даатгал;
- Аавын чөлөө;
- Удаан жил ажилласны урамшуулал;
- Тэтгэвэр тогтоолгосны тэтгэмж;
- Хүүхдийн баярын бэлэг;
- Төрийн болон салбарын шагналын мөнгөн урамшуулал;
- Бусад бүх төрлийн одоогийн хэрэгжиж буй олговор, тэтгэмжүүд.

Та бүхэн 2025-2027 оны Хамтын гэрээний
дэлгэрэнгүй эх хувилбартай

“ОТ ИНФО”

апп-ын нүүр хуудсанд байрлах
“ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭ”-ний хэсгээс
танилцах боломжтой.